



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/36

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийн дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газарт 2020 онд хэрэглэгдэх шатах тослох материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг 25.893.795 (хорин таван сая найман зуун ерэн гурван мянга долоон зуун ерэн тав) төгрөгөөр Сод монгол групп ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн)- т даалгасугай..

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын нягтлан бодогч (А.Саруулбаяр)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012100105